

Чөлөөт сэтгүүл зүй ба «цахим хэвлэл»

Л. Норовсүрэн*

* МУИС, НУФ, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, дэд доктор, профессор

Энэ өгүүллийг ARC-ийн дэмжлэгээр хийсэн "Чөлөөт хэвлэлийн төлөвшил, олон нийтийн санаа бодол" судалгааны хүрээнд бичсэн болно.

Ардчилсан Монгол орны сэтгүүл зүйд нэвтэрч байгаа шинэ зүйлийн нэг нь цахим мэдээллийн хэрэгсэл юм. Арван жилийн өмнө ор сураггүй байсан интернет, цахим хэвлэл өнөөдөр мэдээллийн орон зайд зохих байраа эзэлж, өөрийн гэсэн хэрэглэгчидтэй болжээ. Үүнийг МУИС-ийн дэргэдэх Азийн Судалгааны Төв (ARC)-ийн дэмжлэгтэйгээр тус сургуулийн сэтгүүл зүйн тэнхмээс явуулсан «Олон нийтийн санаа бодол, чөлөөт хэвлэлийн төлөвшил» судалгааны дүн харуулж байна.

Гол төлөв хөдөө орон нутгийн хэрэглэгчдийн дунд явуулсан уг судалгаанд хамрагдагсдын 23,6 хувь нь интернетийн мэдээллийг хамгийн бодитой, шинэлэг мэдээлэл хэмээн үнэлсний дээр тэдний 5,4 хувь нь интернетийг мэдээлэл олж авах байнгын эх сурвалж болгож хэвшсэн ажээ. Энэ өгүүлэлд нийгмийн мэдээллийн харилцааны тэргүүлэх чиглэл болж байгаа цахим хэвлэлийн байдал манайд ямар төвшинд байгааг харуулах зорилт тавилаа.

Даяар сүлжээнд холбогдсон компьютерүүдийн дэлгэцэн дээр байрлаж тогтмол хугацаанд мэдээллээ шинэчилж

байдаг сонин сэтгүүлийг ийнхүү томьёолох болжээ. Анх 1993 онд АНУ-д онлайн сониныг интернетэд байрлуулсан цагаас цахим сонины түүх эхэлдэг. Цахим хэвлэл буюу онлайн бол технологийн эрчимтэй хөгжлөөс хэвлэл мэдээллийн салбарт олгож байгаа боломжийн нэг хэлбэр юм. Өөр олон боломжийг бид одооноос харж эхэлж байна. Хэвлэл мэдээллийн байгууллагууд утасгүй зөөврийн хэрэгслээр мэдээллээ дамжуулах цаг холгүй болсон байна. Хүмүүс гар утсан дээр захиагаа шалгаж, зарим мэдээллийг гар утасныхаа дэлгэцнээс авч байгаа нь түүний эхлэл юм. Түүгээр зогсохгүй гурван хэмжээст мэдээллийн тухай яриа ч зөгнөл биш, бололцоо болов. Тэр бололцоо бодит байдал болсон цагт хүмүүс мэдээллийг зөвхөн хүлээн авагч биш, харин үйл явдалд оролцогч болж тухайн орчны «агаараар» амьсгалах болно. Цахим хэвлэл үүссэнээр цаасан сонинд яаж нөлөөлөх бол гэдэг асуудал ч өнөөдөр санаа зовоохоо больсон байна. Аливаа шинэ мэдээллийн хэрэгсэл гарах бүрд ийм эргэлзээ төрж байсан юм. Радио үүсэхэд сонин яах вэ телевиз гарснаар кино хэрхэх вэ гэх мэт. Тэр бүхэнд хуучин

хэрэгсэл цохигдоогүйн адил цахим сонин ч цаасан хэвлэлийн «дайсан» болохгүй нь илэрхий болов. Харин ч уламжлалт хэвлэлийг улам баяжуулж эвсэг гэр бүлийн хоёр гишүүн шиг бие биенээ нөхөх зүй тогтолтой нь харагдах болов.

Америкийн судлаач Стив Аутинг электрон сонин цаасан хэвлэлийг халах, түүнийг орлох тухай яриа байж болохгүй, харин уламжлалт хэвлэлийн мэдээлэл түгээх аргыг баяжуулах болно хэмээн үзэж байна. Харин интернетэд цахим сонин байрласнаар уламжлалт цаасан сонины зах зээлийг ямар нэг хэмжээгээр өөрчилж эхэлжээ. Цаасан сонины зах зээл газар нутгийн тодорхой хүрээнд хязгаарлагддаг бол электрон сонинд ийм хязгаар байхгүй. Түүний хэрэглэгч тив, дэлхийн хаана ч байж болдгоороо онцлог юм. Цахим болон цаасан сонины мэдээлэл харилцан бие биеэ орлох төлөв ажиглагдах болов. Ялангуяа цаасан сонины мэдээллийг цахим дэлгэцэнд татах явдал ихсэж байна. Өөрөөр хэлбэл цаасан сонины материалыг бараг өөрчлөлгүйгээр онлайн хувилбар дээрээ тавина гэсэн үг юм. Одоо дэлхийн томоохон сонинууд хэвлэмэл мэдээллийнхээ 90 орчим хувийг онлайн дээрээ байрлуулдаг болжээ. Гэтэл бас мэдээллийг шинээр багцалж, агуулга хэлбэрийн холбоос хийж, зураг, дуу, дүрсээр баяжуулан интерактив харьцаанд оруулах, зарим тохиолдолд цаасан сонинд хэвлэгдээгүй мэдээллээр онлайн гаргах явдал ч байна. Тухайлбал АНУ-ын «Ю Эс Эй Түдэй» онлайн хувилбарынхаа 90 хувийг цаасан хувилбарт хэвлэгдээгүй материалаар дүүргэдэг байна. Гэвч энэ хандлага

түгээмэл биш бөгөөд онлайн сонины мэдээллийн үндсэн эх булаг нь цаасан сонины материал болохыг янз бүрийн түвшний судалгаа харуулсан юм. Тухайлбал Америкийн бүх онлайн сонины гуравны хоёр нь дэлгэцэн дэх мэдээллийнхээ 20 хүртэлх хувийг л цаасан сонинд гараагүй материалаар бүрдүүлдэг болохыг «Эдиторс энд публишерс» сэтгүүлийн судалгаа харуулсан бол 1999 онд хийсэн өөр нэг судалгаагаар Америкийн онлайн сонинуудын 78 хувь нь мэдээллийнхээ 95-аас доошгүй хувийг цаасан сонины материалаар дүүргэдэг болохыг тогтоожээ.

Гэтэл онлайн сонинууд эргээд цаасан сонины «ачийг» яаж хариулдаг вэ? гэсэн асуулт гарч ирж болох юм. Тэд интерактив, мультимедиа болон онлайн форум, хайлтын систем, онлайн архив бий болгож, бусад сайт, хэрэгцээт мэдээлэл рүү холбох, вебкэстинг явуулах зэрэг боломжийг уламжлалт сонинд олгодог байна. Энэ бүхэн нь цахим болон цаасан сонин зэрэгцэн орших, гэхдээ бие биеэ тэтгэн хөгжих хандлагатайг бүр ч тодорхой харуулж байгаа юм.

Тэгвэл онлайн бие даасан мэдээллийн хэрэгсэл мөн үү, цаасан сониноос ангид оршиж чадах уу? гэдэг асуудал гарч ирнэ. Онлайн оршин байх хамгийн чухал чанар нь мэдээллийг хязгааргүй алсад түгээдэг явдал юм. Харин тэрхүү мэдээллийг цаасан сонинтой дундаа өмчлөх найрсаг харилцаанд оршин тогтнох ажээ. Бас нэг сонирхолтой тал нь орчин үеийн мэдээллийн хэрэгслийн менежментийн чухал асуудал болох зах зээл, хэрэглэгч, өрсөлдөгч гэх мэт ойлголтууд электрон

сонины хувьд нэн тодорхойгүй байгаа явдал юм. Орон нутгийн ба алсын зайн мэдээлэл, ойрын болон холын зайн зар сурталчилгааг электрон сонины үндсэн зах зээл гэж үзэж байгаа ч түүнийг хянах механизм бүрдээгүй байна. Сонин бизнес мөнийхөө хувьд тодорхой зах зээлд хандаж, түүнийгээ хянаж байх шаардлагын үүднээс үзвэл ийм байгаа юм.

Электрон болон цаасан сонины зах зээлд зарчмын ялгаагүй боловч цахим хэвлэлийн хувьд газар нутгийн өвөрмөц байдал, алсын зайд тархах бололцоо зэрэгтээ тулгуурлан холын зах зээлд хандсан мэдээллийг голлох нь элбэг байдаг. Үүнтэй холбогдуулан өөрийн орны жишээг ч иш татаж болох юм.

Тухайлбал, «Биз Монголиа», «Нью Таймс» зэрэг электрон сонин харь нутагт аж төрж байгаа монголчууд болон Монголыг сонирхогчдод зориулсан мэдээллийг дагнадаг байна.

Өнөө үед хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн хооронд болж байгаа харилцан уусах процесс цахим болон цаасан сониныг ч тойрсонгүй. Өөрөөр хэлбэл цаасан сонинууд өөрийн хуудсанд хэвлэгдсэнээс илүү их мэдээллийг өгөх зорилгодоо цахим сониныг ашиглаж байхад электрон сонин өөрийн ихэнх мэдээллээ цаасан сониноос «хүрдэж» авдаг болоод байна.

Ер нь цахим сэтгүүл зүй үүссэн явдал нь хэвлэл мэдээллийн салбарт гарсан том хувьсгал юм. Шинэ хэвлэл мэдээллийн хэрэгсэл гарч ирсэн нь бие организмд эволюци явагддагийн адил хэвлэл мэдээллийн салбарт гарч буй их өөрчлөлт гэж эрдэмтэн Кавамотогийн хэлсэн нь үнэн үг юм.

Шинэ хэвлэл мэдээллийн хэрэгсэл гарснаар хэрэглэгчдийн мэдээлэл хүлээн авах дадал хэвшлийг ямар нэг хэмжээгээр өөрчилж байгаа нь эргэлзээгүй боловч

бүгдээрээ тийшээ хошуурах төлөвгүй байна. Тэр ч байтугай хэрэглэгчдийн мэдээлэл хүлээн авах дадал нь электрон хэвлэлийн өсөлтийг хязгаар-

лах үйлчилгээтэй нь тогтоогдсон юм. Интернет байнга хэрэглэгчдийн 64 хувь нь зурагт үзэх цагаа, 48 хувь нь ном, сонин сэтгүүл унших хэмжээгээ кибер ертөнц үүсэхийн өмнөх үеэс ямар нэг хэмжээгээр багасгасан тооцоо гарчээ. Мэдээлэл хэрэглэгчдийн олонх нь электрон мэдээллийг компьютерийн дэлгэцнээс уншиж суухын оронд цаасан хэвлэлийг хаа нэгтээ, дуртай цагтаа эргүүлж үзсэн нь дээр гэж үздэг байна. Харин өнөөдөр төрж байгаа цахим нийгмийн жинхэнэ эзэд болох шинэ үеийнхний хувьд байдал өөр байх аж. Өнөөдөр компьютерийн тоглоомд шимтэж, өөр хоорондоо мессеж солилцож, чат өрөөнд ярьж өссөн хүүхэд залуучууд нас

«
Мэдээлэл хэрэглэгчдийн олонх нь электрон мэдээллийг компьютерийн дэлгэцнээс уншиж суухын оронд цаасан хэвлэлийг хаа нэгтээ, дуртай цагтаа эргүүлж үзсэн нь дээр гэж үздэг байна.

»

тогтсон үедээ электрон мэдээлэлд илүү татагдах нь ойпгомжтой юм.

Анхаарч үзүүштэй нэг зүйл бол шинэ ба хуучин мэдээллийн хэрэгслүүдийн гаргаж байгаа бүтээгдэхүүн нь үнэн чанартаа адил байгаа явдал мөн. Тэд үнэндээ нэг нөөцийг хуваан эзэмшиж байгаа юм. Наяад оны дундуур Америкийн хэвлэл мэдээллийн олон хэрэгсэл технологийн хөгжлийн ач холбогдлыг ойлгож, эрчимтэй нэвтрүүлж эхэлсэн. Тэр үед дангаараа зүтгэж байсан хэрэгслүүд ерээд оноос өөр хоорондоо болон өөр төрлийн байгууллагуудтай нэгдэх үйл явцад шилжсэн байна. Ялангуяа хэвлэл мэдээллийн болон харилцаа холбооны байгууллагуудын хооронд нэгдэх процесс илт өссөөр байна. Бас ном хэвлэл, зурагт радио, кино үйлдвэр, компьютерийн салбаруудын хооронд нэгдэх процесс явагдаж байна. Энэхүү нэгдэн нийлэх үйл явц ирээдүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хөгжилд шийдвэрлэх нөлөөтэй болохыг судлаачид тэмдэглэж байгаа юм.

Онлайн сонин гарснаар цаасан сонины захиалгад сөрөг үр дагавар үзүүлэхгүй нь нэгэнт тодорхой болжээ. Нэг үе мэдээллээ онлайн хэлбэрээр интернетэд үнэ төлбөргүй цацах нь цаасан хэвлэлийн захиалгыг бууруулж болзошгүй хэмээн болгоомжилж байв. АНУ-ын Техасын их сургуулийн профессор Силвигийн хийсэн судалгаанаас үзэхэд онлайн сонин цаасан сонины захиалгад төдийлөн нөлөөлдөггүй, харин сониныг сурталчлах маркетингийн хүчирхэг хэрэглүүр болдог төдийгүй, сонин, уншигч хоёрын харилцааг улам ойртуулж, шинэ

зах зээл эзлэхэд нь тусалдаг байна. Иймээс ч орчин үеийн сонины бизнес цаасан болон цахим сонины «гэрлэлт» онцгой ач холбогдолтой гэж «Форт Ворт Стар-Телеграм» сонины менежер Бонни Брэдши хэлжээ.

Нэлээд тохиолдолд цаасан сонин нууд цахим хувилбартай болсныхоо үр шимийг хүртэж байгаа аж. «Вол Стрит Журнал» сонины онлайн хувилбарыг уншигчид жилд 49 доллараар захиалдаг бөгөөд энэ нь Япон зэрэг зарим оронд «Эйшн Вол Стрит» сониныг захиалан уншсанаас хавьгүй хямд тусдаг байна. Тус сонины цаасан хувилбарыг захиалан уншигчдын гуравны нэг нь онлайн хувилбарыг нь давхар захиалан уншдаг байна.

Онлайн хувилбартай болсноор Америкийн олон сонины захиалга өссөн гэж эрхлэгчид нь мэдэгджээ. Хүмүүс онлайн хувилбарыг уншаад зогсохгүй вэбээр дамуулан цаасан сониныг захиалах нь нэмэгдсэн байна. Харамсалтай нь монгол сонинуудын хувьд энэ талаар хийсэн судалгаа алга. Шинэ хэлбэрийн сонинууд эдийн засгийн хувьд яаж оршин тогтнох тухай асуудал гарсаар байна.

Мэдээллийн ертөнцөд шинээр нэвтэрч байгаа онлайн сонины бизнесийн оновчтой загварыг олох нь өнөөгийн тулгамдсан зорилтын нэг болов. Сонин бүрийн онцлогтой холбоотой загвар байж болох юм. Нэг сонины хувьд зар сурталчилгаа үр дүнтэй байхад нөгөөд нь өөр арга хэрэгтэй байж болно. Энэ нь тухайн сонины зах зээл, уншигчдын хүрээ, тэдний хэрэгцээ, техникийн боломж, байршил зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалдаг

байна. Өөрөөр хэлбэл бүх сонинд тохирох бизнес загвар гэж байхгүй юм.

Гэвч онлайн сонинууд захиалгат үйлчилгээ, онлайн реклам, мэдээллийг ивээн тэтгэх, портал вэб хуудас байгуулах, онлайн зарлалын хувилбар хийх зэргийг орлого олж зардлаа нөхөх боломжийн аргуудад тооцож байна. Түүнчлэн сонин өөрөө интернетийн үйлчилгээ үзүүлэх, онлайн архив байгуулах аргууд ч үр дүнгээ өгч байгаа ажээ. Дээрх аргуудаас нэлээд оновчтой нь портал вэб сайт болж байна. Энэ нь зөвхөн сонин хэвлэлийн мэдээллээр хязгаарлаг-дахгүй тухайн орон нутаг, хэсэг бүлэг хүмүүсийн хэрэгцээнд зориулсан янз бүрийн мэдээлэл агуулсан вэб сайт юм. Хэрэглэгч, уншигчид портал сайтаар дамжуулан янз бүрийн бараа таваар худалдан авах, үйлчилгээ хүртэх, эргээд өөрсдийн бараа, үйлчилгээг борлуулах боломжтой болдог байна. Энэ арга нь онлайн хэвлэл зах зээлд бат суурьтай байж, эдийн засгийн хувьд бие даах сайн арга боловч сэтгүүл зүйн уламжлалт зарчмыг зөрчиж, хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг саармагжуулж болзошгүй хэмээн судлаачид болгоомжилж байна.

Шинэ хэрэгсэлтэй холбоотой энэ мэт асуудал манайд ч гарч ирэх болно. Өнөөдөр манай улсад 10 гаруй цахим сонин, сэтгүүл гарч байгаагийн дээр 20 шахам цаасан сонин цахим хувилбартай болсон байна. Тэдгээр нь нэгэн том сүлжээнд багтдаг.

«Mongolia On Line» (МОЛ) нь монголын интернетийн анхны вэб сайт юм. 1996 оны 2 дугаар сараас эхний

хувилбараа гаргаснаас хойш олон дахин шинэчилсэн. Өмнөх хувилбарууд нь зөвхөн вэбмастерын ажиллагаагаар явагдаг байсан бол 2001 оны 9 дүгээр сарын 20-ноос шинэчлэгдсэн хувилбарууд нь бүхэлдээ хэрэглэгчдэд хандсан шинжтэй болжээ. 2000 онд байгуулагдсан МОЛ мэдээний хэсгийнхэн өдөр тутмын мэдээг англи, монгол хэлээр гаргадаг болов. Өнөөдөр МОЛ мэдээний хэсгийн оронд «Чөлөөт урсгал» сувгийг ажиллуулж сэтгүүлч болон хувь хүмүүс мэдээллийг чөлөөтэй түгээх боломжтой болжээ. Өөрөөр хэлбэл идэвхтэй хэрэглэгчид вэбээ бараг өөрсдөө хийх боломжийг олгосон байна. МОЛ саяхныг хүртэл 3000 орчим хэрэглэгчтэй байсан бөгөөд хамгийн сүүлд шинэ хувилбар гаргасны үр дүнд хэрэглэгчдийн тоо 8000-д хүрчээ. МОЛ сүлжээнд фото болон уран зургийн галарей гэсэн хоёр төрлийн галарей, «фото агшин» булан ажилладаг. Хэрэглэгчдийн сонирхлыг татдаг энэ булангийн зургууд өдөр бүр солигддог төдийгүй, сонирхогчид өөрсдийн фото болон зураасан зургийг ч оруулах боломжтой юм.

МОЛ нь манай орны олон нийтийн мэдээллийн шинэ хэрэгслүүдийг агуулсан томоохон сүлжээ юм. Одоо энэ системд байдаг интернет сонин, сэтгүүл, өдөр тутмын болон томоохон сонинуудын зарим вебсайтыг товч танилцуулъя.

Монголын хамгийн том электрон сонин бол 1996 оноос гарч эхэлсэн «E-mail Daily News» юм. Энэ сониныг МРТХЭГ-аас эрхлэн англи хэлээр долоо хоногт таван удаа гаргадаг бөгөөд монгол оронд болж байгаа үйл явдлыг өдөр

өдрөөр тоймлон хүргэдэг хэвийн ажиллагаатай сонин болжээ. Сонины захиалгын үнэ эхлээд таван доллар байсан бол одоо арван доллар болжээ. Электрон шуудан, эсвэл утас факсаар харилцан захиалгын нөхцлийг тохироод байнгын уншигч болох боломжтой юм. Тус сонин нь гол төлөв улс төрийн болон бизнесийн орчин, түүнчлэн соёл, түүхийн сэдвийг ч тусгадаг төдийгүй, дугаар бүртээ валютын ханш, цаг агаарын мэдээ оруулдаг байна.

Монгол орныг гадаадад сурталчлахад чиглэсэн хэд хэдэн онлайн гараад байгаагийн нэг нь «Biz Mongolia» юм. Энэ сониныг

«Инфеком», «Жамба интернейшнл» гэсэн хоёр компани эрхлэн 2001 оны 1 дүгээр сараас долоо хоног тутам гаргах болжээ. Монголын эдийн засгийн байдал, зах зээлийн багтаамж, бизнесийн орчин зэрэгт мэргэжлийн дүн шинжилгээ хийх, түүнийг дэлхийн эдийн засгийн интеграцчилалд хамруулах боломжийн тухай мэдээллийг англи хэлээр түгээх зорилготой.

1998 оноос «МОНЦАМЭ» агентлагийн сайт дээр гарч эхэлсэн «Mongol messenger» 2001 оноос долоо хоног тутам «Бодь компьютер» компанийн сайт дээр гарах болжээ. Сонины дугаар бүрт танилцуулга, шинэ болон өмнөх дугаарын товчоо, рекламн тариф, захиалгын хуудас зэргийг тавьж хэвшжээ. Сонин рекламн тариф нийтэлдгээрээ бусад цахим сониноос ялгардаг бөгөөд А-3-ын

хэмжээтэй сайт (нүүр)-д нийтлэх рекламн үнэ 300 ам доллар байдаг ажээ. Ерөнхийдөө танилцуулгын шинжтэй бөгөөд англи хэлээр товч өгүүлэмжтэй гардаг сайт юм.

«Mongolia This Week» сонин 1999 оноос эрхлэн гаргагчийн тодорхой хаяггүй гарч эхэлсэн байна. 2001 оноос эхлэн

долоо хоногт нэг удаа цаасан хувилбар гаргаж байжээ. Уг сайтыг уншихын тулд заавал захиалах хэрэгтэй. Жилийн захиалгын үнэ 150 доллар бөгөөд уншигч тусгай түлхүүр үгээр уг сайтад нэвтэрдэг. Оруулсан

материалынхаа гарчгийг нийтэлсэн байдаг тул сонирхсон сэдвээ олж үзэхэд дөхөмтэй.

2000 оноос нэгэн америк хүний сайт дээр «UB Post» сонин англи хэлээр гарч эхэлсэн байна. Уг сайтаа долоо хоног бүр сольдог. Гол төлөв бизнес, соёл, хааяа олон улсын мэдээ тавьдаг. Хэмжээний хувьд хамгийн том сайт бөгөөд А-2-ын 8 нүүртэй тэнцэхүйц юм.

1996 онд эх сууриа тавьсан «МН компьютерийн сэтгүүл» нэртэй анхны цахим сэтгүүл өнөөдрийг хүртэл тасралтгүй гарч байна. Анх «Датаком» санаачлан үүсгэсэн энэ сэтгүүлийг 2000 оноос «Нээлттэй мэдээлэл» төв хариуцах болж ерөнхий редактороор нь С.Уянга, хариуцлагатай нарийн бичгийн даргаар нь Х.Марал нар ажиллаж эхэлжээ.

«

Тус сэтгүүлийн сайт цэгцтэй, үзэмжтэйн дээр арвин мэдээлэлтэй юм. Бас олон нийтийн компьютерийн боловсролд зориулсан нийтлэл нь хэрэглэгчдийн сонирхлыг татдаг байна.

»

Тус сэтгүүлийн сайт цэгцтэй, үзэмжтэйн дээр арвин мэдээлэлтэй юм. Бас олон нийтийн компьютерийн боловсролд зориулсан нийтлэл нь хэрэглэгчдийн сонирхлыг татдаг байна. Компьютерийн өргөн хэрэглэгддэг программ, компьютер тоглоом, интернетийн сурах бичиг зэрэг олон зүйлийг байрлуулсан байдаг. Сэтгүүл 1999-2000 онд нийт 20 дугаар гаргаж байснаа 2001 оноос гаралт нь цөөрчээ. Үүнийг цаасан хувилбарын орлого буурахаас сэрэмжилсэн хэрэг гэж ажиглагчид үзэж байна.

Жинхэнэ «Online magazine» буюу цахим сэтгүүлийн төрхөөр гарсан сэтгүүл гэж өөрийгөө танилцуулсан сайт бол «Гэр» юм. Интернетэд хэсэг бүлгээр заримдаа тохиодлын чанартай ч гэж хэлж болмоор мэдээлэл оруулдаг сайтуудаас «Гэр» өвөрмөц төрхтэй. Өөрөөр хэлбэл тодорхой сэдэв, чиглэлээр материалаа урьдчилан бүрдүүлж, түүнийгээ цэгцэлж төрөлжүүлэн нүүр, буланд хувааж нэг бүхэл бүтэн дугаар болгон тавьдгаараа жинхэнэ сэтгүүлийн шинжийг бүрдүүлдэг онцлогтой.

Эрхлэн гаргагч Монгол дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн газар мэргэжлийн өндөр төвшинд хүрсэн интернетийн сэтгүүл гаргах замаар монголын сэтгүүл зүйн чанарыг ахиулахад чиглэсэн төсөл гэж нэрлэжээ. Сэтгүүлийн ерөнхий агуулга нь монгол орон, монголчуудын амьдрал, үндэсний онцлогийг сурталчлахад чиглэдэг байна. Монголд электрон хэвлэл мэдээллийг хөгжүүлэх зорилготой энэ сэтгүүлийн анхны дугаарыг 1998 оны 9 дүгээр сард НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн сайт дээр

тавьжээ. Үндэсний уламжлал, зан заншлыг харуулсан материалууд нь гадаадынхны сонирхлыг татдаг байна. Тухайлбал монгол гэрийг яаж барих технологийг үзүүлсэн байх жишээтэй. Уншигчдынхаа дунд төрөгдөл (эссе) бичих, фото нийтлэл туурвих уралдаан зарлан дүгнэдэг, Нийтлэлийн үйл ажиллагаанд идэвхтэн бичигч, орчуулагчдыг өргөн оролцуулж, тэдний зураг танилцуулга тавьдаг зэрэг нь сэтгүүлийн олон нийтийн үндсийг бэхжүүлэхэд тус болдог ажээ.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн албан ёсны бус хэвлэл гэсэн статустай энэ сэтгүүлийн материалыг тус байгууллагын албан ёсны байр суурийг дурдахгүйгээр чөлөөтэй ашиглаж болох бөгөөд энэ тохиолдолд гагцхүү "Гэр"-ийг дурдах хэрэгтэй гэнэ. Анхнаасаа англи, монгол хэлээр гарч байгаа энэ сэтгүүл нэлээд удаж гардаг нь их төлөв танин мэдэхүйн шинжтэй, хуучирдаггүй материалаар бэлтгэдэгтэй нь холбоотой аж. Анх гарч эхлэхдээ цаасан хувилбартай болно гэж зарласан боловч одоогоор хэрэгжээгүй байна.

Гадаадад суугаа монголчуудын «Цахим өртөө» интернетийн гишүүн Ш.Баатар (Сан-Франциско), Д.Цэрэнбат, П.Байка (Их Британи) нарын үүсгэл санаачлагаар хоёр сар тутмын «Цахим улаач» сэтгүүл гарч эхэлжээ. Тус сэтгүүлийн анхны дугаарт «Цахим өртөө» сүлжээний гишүүн бидний хамтран гаргах энэхүү сэтгүүлийн хуудаснаас уншигч авхай та даян дэлхийгээр таран суугаа Монгол түмнийхээ санаа бодлыг тольдон, гадаад улс орнуудад болж буй үйл явдлуудыг цаг тухайд нь олж

мэдэх болно. Мөн Монгол түмний үндэсний их соёлыг эрхэмлэн дээдэлж, уламжлан бадруулах, төрөлх сайхан монгол хэлнийхээ үгийн баялгийг үүдлэн нээж, өнөө ба ирээдүйд түмэн олноороо хүмүүн бичгээ хэрэглэх эрхэм нандин үйлсийн төлөө «Цахим улаач» хичээнгүйлэн зүтгэнэ» гэж зорилгоо тодорхойлсон байв.

Газар бүрээс санаа бодлоо нэгтгэж зөвшилцөн чамбай боловсруулсан сайн нийтлэлтэй, үнэ төлбөргүй сэтгүүл юм. Дан ганц монгол хэлээр гардаг бөгөөд нэг удаад таваас цөөнгүй сайт буюу хуудсаар гардаг. Уншигчдын тоо нь 7 мянгаас давжээ.

1999 оноос сэтгүүлч Д.Цэрэнжавын үүсгэл санаачлагаар «Монголын ОНМХ-ийн тойм» сэтгүүл «ОНМХ-ийн ажиглагч», «ОНМХ-ийн менежмент» гэсэн хоёр сайттайгаар гарч эхэлжээ. Одоогоор арав шахам дугаар гаргаад байгаа энэ сэтгүүл хэвлэл мэдээллийн салбарын үйл ажиллагааг судалдаг, сонирхдог хүмүүст зориулагджээ. Хэвлэл мэдээллийн салбарт болсон үйл явдал, тулгамдсан асуудлыг тусгасан тойм, тайлбар, ажиглалт, санал бодол, дүн шинжилгээ нийтэлдэг нь уншигчдын сонирхол татдаг. Түүнчлэн шинээр гарсан мэдээллийн хэрэгслүүдийг алдалгүй мэдээлдэг.

«ОНМХ-ийн ажиглагч» сайтад мэдээллийн хэрэгслийн хүрээнд болж буй үзэгдэл, үйл явдлын талаарх зохиогчийн

үнэлэлт дүгнэлт, байр суурийг илэрхийлдэг. Тиймээс ч сайт бүр дээрээ «бие даасан байр суурь, мэргэжлийн дүн шинжилгээ» гэж бичсэн байдаг. Харин «ОНМХ-ийн менежмент» нь сэдэвчилсэн булангийн маягтай гардаг. Нэг сайтад нэгл асуудлыг сонгож түүгээрээ дагнан гардаг «Өдрийн асуудал» гэсэн булантай. Ажиглагч, менежмент хоёр нэг удаад тус бүр таван сайтаар гарна. Бас цаасан хувилбартай. Монгол хэлээр гардаг мэдээлэл арвинтай, макет загвар сайтай энэ сэтгүүлийн электрон хувилбарыг 1800 гаруй хүн үздэг байна. 1999 оноос сэтгүүлч Л.Бадамханд, Б.Лутаа нар монголд жуулчлагчдыг татах зорилгоор байгалийн үзэсгэлэнт газар, хүмүүсийн амьдралын

«
Монголын өнөөгийн цахим сонин, сэтгүүл, вэбсайтууд гол төлөв улс орноо гадаад ертөнцөд нээлттэй болгоход чиглэсэн нийтлэл, мэдээллийг түлхүү тавьж байна.
»

хэв маяг, ёс заншил гэх мэтийг голлон бичдэг «Mongolia today» сэтгүүлийг үүсгэн байгуулжээ. Нэг удаа 6-7 сайтаар гардаг. Мэргэжлийн өндөр төвшинд бэлтгэсэн бичвэр, дизайн, зураг чимэглэлтэй. Цаасан хувилбаргүй цэвэр онлайн сэтгүүл бөгөөд бусад сэтгүүлээс тоолууртайгаараа ялгаатай аж. Арав шахам дугаар гаргаад байгаа энэ сэтгүүлийг өнгөрсөн хугацаанд 50 мянга шахам хүн үзсэн байна.

Америкт байдаг монголчууд хамтран 1999 оноос «Миний Монгол» нэртэй сэтгүүл гаргажээ. АНУ-д болж байгаа цаг үеийн үйл явдлыг голчлон мэдээлдэг. Бас харьд суугаа монголчуудын үзэл бодол, амьдрал байдал, баяр гуниг зэргийг аль

болох өргөн тусгахыг зорьдог байна. Нэг удаа 6-8 сайттайгаар нийт 9 дугаар гаргажээ. Уг сэтгүүлээс монголын цаг агаарыг харж, бас монгол дуу хөгжим захиалж болно. Цаасан хувилбаргүй бөгөөд үзэгчдийнх нь тоо 20 мянгад хүрээд байгаа ажээ.

Анх 1992 онд «Бодь компьютер» компани Монголын сонинуудыг интернетэд оруулах үйл хэргийг эхлэх болсноо албан ёсоор зарлаж, сонин хэвлэлийнхэнтэй уулзалт зохион байгуулжээ. Ерээд оны хоёрдугаар хагасаас энэ санаачилга идэвхтэй хэрэгжиж эхэлсэн бөгөөд одоогоор мэдээллийн хорь шахам хэрэгсэл өөрийн вэб сайттай болсон байна.

Хамгийн анх 1996 онд «Өнөөдөр» сонины компьютерийн төвийг хариуцдаг «Аргамаг системс» компанийн захирал Жагдагдоржийн санаачлагаар тус сонины сайт нээгдсэн байна. 1997-1999 оныг дуустал уг сайт байнга шинэчлэгдэж байсан боловч сүүлийн жилүүдэд эрч нь саарчээ. Үүний дараа 1997 онд «Ар-дын эрх» интернетэд сайтаа байрлуулжээ. Энэ сонины сайт 1998-1999 онд маш сайн ажиллаж байв. Сонин гарснаас хойш хоёр хоногийн дотор бараг бүх нийтлэлээ сайт дээрээ тавьдаг байлаа. Гэвч удалгүй сайтдаа тавих анхаарал нь суларч 2000 онд долоо хоногийн дараа шинэ дугаараа оруулдаг байсан бол 2001 онд хааяа нэг тавьдаг болжээ. 1999 оноос «Өдрийн сонин» болж хувирсан энэ сониныхон цахим хувилбараа шинэчлэн сэргээхээр бэлтгэж байгаа ажээ.

Түүнчлэн 1999 онд «Зууны мэдээ», «Монголын мэдээ», 2000 онд «Үнэн»

сонин вэб сайттай болсноор манай орны өдөр тутмын сонинууд интернетэд цахим хувилбараа илгээдэг болжээ.

Эдгээрээс гадна «Хүмүүс», «Шар сонин», «Хүмүүсийн амьдрал», «Монголын нэг өдөр», «Залуус», «Үндэстэн», «Дээдсийн хүрээлэн», «Маш нууц», «81 суваг», «Үг», «Бөх», «24 цаг» зэрэг сонин интернетэд сайттай болсон байна.

Дээр дурьдсан цахим хэвлэлийн байдлаас харахад манай оронд электрон хэвлэлийн бүхэл бүтэн тогтолцоо буй болох эхлэл тавигдаж, тэр нь цахим сонин, цахим сэтгүүл, уламжлалт хэвлэлийн цахим хувилбар гэсэн бүтэцтэй болсон байна.

Монголын өнөөгийн цахим сонин, сэтгүүл, вэб-сайтууд гол төлөв улс орноо гадаад ертөнцөд нээлттэй болгоход чиглэсэн нийтлэл, мэдээллийг түлхүү тавьж байна. Энэ зорилгоор улс төрийн амьдрал, түүх, соёл, зан заншил, байгалийн үзэмж, түүний баялгийг сурталчилсан зүйл зонхилж, монгол, англи хэлээр гардаг байна. Түүнчлэн АНУ, Их Британи зэрэг гадаад оронд суугаа монголчууд төрөлх орноо сурталчлах, хөгжил цэцэглэлтэд нь тус болох, харилцан холбоотой ажиллаж, амьдрах зорилгоор цахим сонин гаргадаг болов.

Өнөөдөр Монголын электрон сэтгүүл зүй хөгжлийнхөө эхний шатанд явж байна. Иймээс нийтлэлээ тогтмолжуулж, оновчтой чиглэлийг хэвшүүлэхэд дадлага туршлага дутаж, зохих бэрхшээлтэй тулгарах явдал гарсаар байна. Нэг хэсэг цахим хувилбар хэлбэр хийц сайтай ч шинэ сэргэг мэдээллээр хомс байхад нөгөө

зарим нь цаасан дугаараа үг үсэггүй хуулбарлаж байна. Үүний оронд гол гол мэдээллүүдээ тоймлох, товчлох, агуулгыг танилцуулах зэргээр боловсруулж, цаасан хувилбарыг захиалж унших хүсэл төрүүлэхүйц маркетингийн бодлого явуулахад болохгүй гэх газаргүй.

Цахим хувилбаруудын мэдээллийн шуурхай чанар нэн хангалтгүй байна. Жилд гурав дөрөвхөн удаа цахим хувилбараа шинэчилдэг сонин цөөнгүй байгаа төдийгүй, зарим сонин сүүлийн хоёр жилд сайтаа шинэчлээгүй байна. Интернетийн сэтгүүл зүйг дэлхийн хамгийн шуурхай сэтгүүл зүй гэж үздэг байтал манайд хамгийн удаан нь болчихоод байгааг анхаарагүй байх аргагүй. Зарим сонины мэдээллийн сонголт тааруу, редакцийн хаяг, эрхлэн гаргагчийн нэр усгүй байх явдал ч үзэгдсээр байна.

Улсын хэмжээгээр 200 гаруй тогтмол хэвлэл байнга гарч байгаатай харьцуулахад вэб сайттай сонины тоо хэт цөөн байгааг ч бодолцох учиртай.

Эцэст тэмдэглэхэд дэлхий дахины хандлага болсон мэдээллийн даяаршилд аль хэр хамрагдаж, интернетийн сэтгүүл зүйг яаж хөгжүүлснээр ардчилсан Монгол улсын чөлөөт сэтгүүл зүйн хөгжлийн төвшин тодорхойлогдох болно.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Ворошилов В.В. 2002. Журналистика. СПб.
2. Борчулуун Я. 2002. Онлайн хэвлэлийн одоогийн чиг хандлага. // "Сэтгүүлч".

3. Прохоров Е.П. 2000. Демократия и журналистика. Москва.
4. Беспалов А.Г. 2002. История мировой журналистики. Ростов-на-Дону.
5. Straubhaar, LaRose. 2000. Media now. Communications Media in Information Age. Wadsworth.
6. Stanley G. Baran, Dennis K. Davis. 2000. Mass Communication Theory. Wadsworth.
7. Jack Fuller. 1996. News values. Ideas for an information age. Chicago.

Free Press and Online

The electronic journalism, which has been developed in Mongolia for last 10 years, was discussed in this article.

At the beginning of this article, the origin of the world's internet was discussed. Then the development of internet service in Mongolia and formation of online media and journals and mutual influences of electronic media and newspapers and the future perspective of them were discussed. Their information and publication intertion and feature were discussed too.